БАТЛАВ:
ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД ЭРДЭНЭТ ХОТЫН ЗАХИРАГЧ
Б.ЗОРИГТБАЯР

“ОРХОН АЙМАГ, БАЯН-ӨНДӨР СУМ, ЭРЧИМ ХӨРӨӨЛЛЫН БАРИЛГАЖИЛТЫН ТӨСӨЛ ХЭРЭЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ЗУРАГ ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны ... сарын ... өдөр Дугаар БТ-2025/02 Эрдэнэт хот

1.	**Ерөнхий төлөвлөгөө боловсруулах үндэслэл**	- Хот байгуулалтын тухай хуулийн 8.1.1, 9.1.4 дэх заалт; - Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль; - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа - 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хөгжүүлэх үйл ажиллагааны зорилтын 3.2.5; - Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 202 дугаар тогтоол “150 мянган айл-Орон сууц” үндэсний хөтөлбөр; - Хангайн бүсийн тулгуур төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /2005-2020/; - Орхон аймгийн ИТХ-ын 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 06/02 дугаар тогтоолоор батлагдсан Баян-Өндөр сумын Баянцагаан багийн нутаг дэвсгэрт Шарчулуут уулын энгэрт 120 га газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө.
2.	**Баримт бичгийн үе шат**	Барилгажилтын төслийг боловсруулахдаа дараах 2 үе шатны дараалаар хийнэ. Үүнд: - Техникийн төсөл - Ажлын зураг
3.	**Газар нутгийн хэмжээ (га)**	- Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан баг Шар чулуутын энгэр; - Төлөвлөлтөд хамрах газар нутгийн хэмжээ 14 га хүртэл. /Гүйцэтгэгч нь төлөвлөлтөд хамрагдах нутаг дэвсгэрийн хил заагийг орон нутагтай харилцан тохирч хийнэ./
4.	**Баримт бичгийн бүрдэл, шийдвэрлэх асуудал**	**Байршлын тойм:** “Хот байгуулалтын тухай” хуулийн 12.9 дэх хэсэг болон холбогдох хот төлөвлөлтийн норм, нормативын баримт бичгийн дагуу /инженер-геологи, байр зүйн зураглал, газар нутаг, хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчин, дэд бүтцийн судалгаа болон бусад судалгааны тайлан г.м/ боловсруулна. - Хөгжлийн чиг хандлага, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан байдал (Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан байршил,

137

		гудамж, замын сүлжээ, инженерийн хангамжийн төлөвлөлтийг үзүүлнэ.); **Барилгажилт, газар ашиглалтын өнөөгийн байдал, байр зүйн зураглал;** - Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээний хүрээнд төлөвлөлт хийгдэх газрын барилгажилт, газар ашиглалт /эзэмшил, өмчлөл, ашиглалт/, гудамж, замын болон инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний өнөөгийн байдлыг судлан, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд хийгдсэн хот байгуулалтын иж бүрэн үнэлгээг тодотгон боловсруулах; - Барилгажилт, газар ашиглалтын өнөөгийн байдал, байр зүйн зураглал; - Хүрээлэн буй орчны байдал (агаар, хөрс, усны бохирдол); - Нийгэм, эдийн засгийн төлөвлөлт (ажлын байр, барилгын материал); - Гудамж, замын сүлжээний төлөвлөлт,гудамжны хөндлөн огтлолын байгуулалт; - Авто замын тэнхлэгийн улаан шугамын төлөвлөлт; **Барилгажилт, архитектур орон зайн төлөвлөлтийн зураглал:/М1:500/** - Газрын гадаргуугийн зохион байгуулалтын схем, барилгажилтын төрх, өндөр намын харьцаа, харагдах байдал, 3D; - Барилга байгууламжийн зохиомжийн зураг, давхрын байгуулалт; - Богино, дунд, урт хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийн зураг; - Барилгажилтыг дэмжих, хязгаарлах, хориглох бүсийн төлөвлөлт; - Архитектурын жижиг хэлбэрүүд (усан оргилуур, сандал, сүүдрэвч, хогийн сав)- ийг /М1:20/ тохижилтын байгууламжийн хийц, хэсэглэлийг хөндлөн огтлолоор харуулна; - Эхний ээлжийн барилгажилт, газар зохион байгуулалтын төлөвлөлт. **Зам, талбайн өндөржилт, төлөвлөлт, инженерийн бэлтгэл арга хэмжээ: /М1:500/** - Байрзүйн дэвсгэр зураг болон өндөржилтийн зураглалыг М1:500 дээр нарийвчлан гаргах; - Одоо баригдсан болон төлөвлөлтөөр баригдах барилга байгууламжийн өндөржилтийг тооцож, гадаргуугийн болон хөрсний ус зайлуулах шийдлийг оновчтой төлөвлөн боловсруулах; - Төлөвлөлтийн талбайн үерийн эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлээс хамгаалах урьдчилсан арга хэмжээ авах, үерийн

		хамгаалалтын байгууламжийн одоогийн нөхцөл байдалд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, тоосжилт орчны бохирдлыг бууруулах арга хэмжээг зохистой хэрэгжүүлэх асуудлыг шийдвэрлэх; - Инженер-геологи, гидрологи, гидрогеологийн судалгаа хийх; - Үерийн хамгаалалтын далан суваг, зам талбайн борооны ус зайлуулах нэгдсэн шугам сүлжээ төлөвлөх; - Эрдэнэт хотын үерийн далан, инженерийн байгууламж шинэчлэх, гэр хорооллын усан хангамжийг сайжруулах "Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал төсөл"-ийн үерийн далантай уялдах эсэхийг судлах, боломжгүй бол өөр хувилбар гаргах; - Авто замын тэнхлэгийн улаан шугамын төлөвлөлт;. **Инженерийн дэд бүтцийн хангамж, эх үүсвэр, шугам сүлжээ: /М1:500/** **Дулаан хангамж:** - Дулаан хангамжийн төлөвлөлтийг барилгажилтын төслийн үе шаттай уялдуулан тооцож хэрэгжилтийг үе шаттайгаар тооцож гаргах; - Одоо байгаа дулаан хангамжийн сүлжээний ашиглалтын түвшин, насжилт, хүчин чадлын судалгаа гаргах. **Цахилгаан хангамж:** - Дэд станц, хуваарилах байгууламж, ХТП, АТП, КТП болон цахилгааны шугам сүлжээний байршил, хүчин чадал, хүчдэлийн түвшин, ачааллын хувь, насжилтыг нарийвчлан судлах; - Одоо байгаа болон төлөвлөлтийн ачааллыг нарийвчлан тооцож баланс гаргах, олгогдсон цахилгаан эрчим хүчний хэрэглээг тодорхойлох; - Сэргээгдэх эрчим хүчний эс үүсвэрээс хангагдах хэсгийн мэдээлэл, ачаалал болон эх үүсвэрийн хүчин чадлыг тооцоолох; - Газрын өндөржилт, налуугийн түвшнийг тооцож, автомашин саадгүй орж, гарах, боломжтой байхаар дэд станц болон цахилгааны бусад байгууламжуудыг төлөвлөх; - Цахилгаан хангамжийн төлөвлөлтийн бүх шатанд Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор эрчим хүчний хэмнэлтийг хангах техникийн шийдлийг гаргах;

		- Цахилгаан хангамжийн төлөвлөлтийг барилгажилтын төсөлтэй уялдуулан, үе шаттай төлөвлөх. **Усан хангамж:** - Усны хэрэглээний одоогийн байдал, шугамын хүчин чадал, насжилт, өргөтгөл хийх эсэх судалгаа гаргах **Ариутгах татуурга:** - Төвлөрсөн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийн тооцоо судалгааг гаргах, хангагч байгууллагатай зөвшилцөн тодорхойлох; - Өндөржилтийн судалгаанд үндэслэн бохир усны шугамын төлөвлөлт хийх. - Холбоо мэдээлэл: - Улсын болон хувийн хэвшлийн шилэн кабелын сүлжээний мэдээллийг гаргах. - Сэргээгдэх эрчим хүч; - Камерын нэгдсэн сүлжээний төлөвлөлтийг холбогдох норм, дүрмийн дагуу нарийвчлан боловсруулах; Инженерийн хангамжийн хэрэглээ, хэрэгцээг одоо байгаа болон төлөвлөгдөж байгаа хүн амын үзүүлэлтээр тооцно, Инженерийн дэд бүтцийн хангамжийн үндсэн шийдлүүдийн хүрээнд инженерийн шугам сүлжээний нэгдсэн схем боловсруулж цэвэр ус, бохир ус, дулаан, цахилгаан, хийн хангамж, гадна гэрэлтүүлэг, телефон, радио телевизийн хангамжийн сүлжээ, эх үүсвэр, гадаргуугийн ус зайлуулах ил болон далд байгууламж, тэдгээрийн хүчин чадал, хийц, материалын үндсэн үзүүлэлтүүдийг газар доорхи орон зай ашиглалтын хөндлөн огтлолын зургийн хамт үзүүлнэ. **Цэцэрлэгжилт, ногоон байгууламж:/М1:500/** - Орчмын нутаг дэвсгэрийн ногоон бүс, хотын чанартай, хорооллын чанартай ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн нэгдмэл систем, тэдгээрийн харилцан хамаарлыг төлөвлөлтөд тусган уялдуулах; - Ногоон байгууламжийн бүтэц, ландшафтыг зураг төсөлд онцгойлон судалж, мод, бут, сөөгийн нэр төрлийг сонгохдоо хөрсний үржил шим, байгаль орчны бохирдолд тэсвэрлэх чанар, байгалийн нөхцөлд нийцүүлэн сонгож төлөвлөх; - Нийтийн ногоон байгууламжийг бичил хорооло́лд төлөвлөх. **Нийгмийн дэд бүтцийн хангамжийн төлөвлөлт /М1:500/** - Одоогийн нийгмийн дэд бүтцийн хангамжид хийсэн дүн шинжилгээнд үндэслэн нийгмийн дэд

		бүтцийн байршлыг тодорхойлж, цаашдын өсөн нэмэгдэх эрэлт, хэрэгцээнд үндэслэн хүчин чадлыг тодорхойлох; - Нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийг гудамж замын сүлжээ,суурьшлын бүсүүдтэй уялдуулан норм дүрмийн дагуу зохистой үйлчлэлийн хүрээнд байхаар төлөвлөх; - Суурьшлын бүсийн хүн амд үйлчлэх төрийн байгууллага, цэцэрлэг, сургууль, эмнэлэг, иргэдийг чийрэгжүүлэх спортын талбай, байгууламж, усан сан, үзвэр үйлчилгээ, соёлын барилга байгууламжийн эдэлбэр газрын хэмжээг тодорхой зааж төлөвлөх; **Гамшгийн менежментийн төлөвлөлт /М1:500/** - Гал унтраах автомашиныг усаар цэг, гудамж замын гидрант; - Түр хоргодох байр, цуглах талбай, дуут дохио; - Нүүлгэн шилжүүлэх, авран хамгаалах; **Хог хаягдлын менежмент /М1:500/** - Хорооллын хог хаягдлыг төвлөрүүлж тээвэрлэхэд зориулагдсан тодорхой цэгүүдийн схем М:500; **Тайлбар бичиг:** - Барилгажилтын төслийг боловсруулсан үндэслэл, зорилго, хамрах хүрээ, бүрэлдэхүүн, аргачлал, арга зүй, ажлын төлөвлөгөө, хуваарь; - Хот байгуулалтын суурь судалгаа, дүгнэлт, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, харьцангуй давуу, сул талуудын харьцуулалт, хөгжилд нөлөөлөх хүчин зүйлүүдийн тодорхойлолт, эдийн засгийн тооцоо болон өмнөх ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд өгсөн үнэлэлт, дүгнэлт; - Орон зайн төлөвлөлтийн үндсэн шийдэл; - Богино, дунд, урт хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг гаргах, ээлж дараалыг төлөвлөлтийн үе шатны дагуу тогтоох, хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилтийн тооцоог хийх г.м/; - Эхний ээлжинд хэрэгжүүлэх инженерийн болон нийгмийн дэд бүтцэд шаардагдах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах; - Техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлт; - Хүрээлэн буй орчин болон түүх, соёл, уран барилгын дурсгалыг хамгаалах, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө зэргийг нарийвчлан гаргаж, төлөвлөлтийн холбогдох зураг, зургийн даалгавар зэрэг материалыг хавсаргана. - Тайлбар бичиг, хөрөнгө оруулалтын тооцоо; **Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө:**

		- Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд хэрэгжих томоохон төсөл, арга хэмжээний байршлын бүдүүвч зураг; **Товч танилцуулга:** - Хэвлэлийн эх бэлтгэл, цаасны формат /сонголтоор/ - Барилгажилтын төслийн хураангуй; - Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хураангуй; - Барилгажилтын төслийн онцлог давуу талыг тусгасан хурлын тараах материал; - Олон нийтэд зориулсан тараах материал /брошюр, анимэшн/; **Барилгажилтын төслийг хот байгуулалтын нэгдсэн мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага:** **1.Бичиглэлийн баримт бичиг** - Тайлбар бичиг /*.doc, *.pdf, *.xlsx / ; - Батлагдсан баримт бичиг скайнер /*.pdf, *.jpg/; **2.Зураглалын баримт бичиг** - Ажлын файл /*.dwg, *.shp, *.skp, lumion, *.max, *.cdr/; - Батлагдсан баримт бичиг скайнер /*.jpg, *.pdf/; **3.Товч танилцуулга** - Олон нийтийн хэлэлцүүлэг, хурлын танилцуулга /*.ppt/; Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эхлэлийн, дундын, эцсийн тайлангийн хугацаанд бичиглэлийн баримт бичгийг А4, зураглалын баримт бичгийг А1 форматаар 1% захиалагчид, улсын экспертизийн дүгнэлт гарч, эрх бүхий байгууллагаар батлагдсан хот байгуулалтын баримт бичгийг орон нутгийн архивд эх хувиар 1%, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт тус бүр хуулбар 1% үйлдэж цаасан хэлбэрээр хүлээлгэн өгнө. Хот байгуулалтын баримт бичгийг тоон байдлаар DVD дээр бичиж хүлээлгэж өгөх: **Үүнд:** - Байр зүйн дэвсгэр зураг, инженер-геологийн судалгааны тайлан /*doc, зураглал *dwg/; - Ерөнхий төлөвлөгөөний файл /*dwg, *shp/; - Зураглалын материал /*jpeg/; - Тайлбар бичиг /*pdf, *word/; - Холбогдох хурлын тэмдэглэл, шийдвэр скайнердсан /*doc, *pdf;/ - Зөвшөөрөлцсөн байгууллагын шийдвэр скайнердсан /*pdf/; - Улсын экспертизийн дүгнэлт скайнердсан /*pdf/; - Батлагдсан шийдвэр скайнердсан /*pdf/ тус тус хуулж 3 хувь бэлтгэж Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Аймгийн Засаг даргын

		тамгын газар, тухайн орон нутгийн аймгийн Архив, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газарт тус бүр хүлээлгэж өгнө. - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем"-д нэвтрэх эрх авч баримт бичгийг төслийн шатанд оруулан холбогдох байгууллагаас цахимаар санал авах, батлагдсаны дараа эцсийн байдлаар хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний орон зайн мэдээллийг цахим системд оруулна. **Тайлбар:** Ажлын зургийг гүйцэтгэхдээ "Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд барилга байгууламж, тохижилт, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн өгөгдөл оруулах" журмыг баримтална. - Батлагдсан ажлын даалгаварт тусгагдсан иж бүрэн зураг төслийн эх хувь, тайлбар бичгийн хамт хэвлэмэл болон тоон байдлаар CD-нд 4 хувь үйлдэж Орхон аймгийн архив, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Хот байгуулалт, барилга захиалагчийн албанд тус бүр хүлээлгэн өгөх. **Газар зохион байгуулалтын төлөвлөлт:** - Тухайн нутаг дэвсгэрийн газар ашиглалтын өнөөгийн байдал болон төлөвлөлтийн үндсэн үзүүлэлтүүдийн харьцуулалт хийх; - Газар зохион байгуулалтын төлөвлөлтөөр барилгажилтын төслийг хэрэгжүүлэх бодлогыг тодорхойлох; - Үүссэн суурьшлыг оновчтой зохион байгуулах төлөвлөлтийн шийдлүүдийг дэвшүүлэх, үе шатуудад хуваах; - Цуцлах шилжүүлэхтэй холбоотой газрын харилцааны шийдлийг үндэслэлтэй тодорхойлох, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөлттэй гаргах.
5.	**Онцгой нөхцөл**	- Суурьшлын бүсийг 2200 өрхөөс хэтрэхгүй байхаар төлөвлөлт хийх; - Барилгажих орчин, ногоон байгууламж, орчны тохижилт, авто зогсоолыг бүсчлэл тогтоон ногоон байгууламж орчны тохижилтын авто зогсоол дайран өнгөрөхгүй байх; - Төлөвлөлт нь иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд аюул учруулахгүйгээр бат бэх тогтвортой байх; - Төлөвлөлтийн талбайд шаардлагатай бол инженерийн хангамжтай дэд төвийн судалгаа, байршил, хүчин чадлыг тодорхойлж тусгах; - Хот төлөвлөлтийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоотой төлөвлөлтийн зарчмыг баримтлах;

		- Нийгмийн болон инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийг хот төлөвлөлтийн нормын дагуу төлөвлөх; - Амралт зугаалгын бүс, ногоон байгууламж, ногоон зурвасыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн норм дүрмийн дагуу төлөвлөх; - Одоо байгаа инженерийн дэд бүтэцтэй уялдсан байх; - Нийтийн тээврийн болон авто зогсоол, дугуйн замын төлөвлөлтийг тусгах; - Ногоон хөгжлийн бодлого, ногоон барилгын шаардлагыг хэрэгжүүлэх, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх; - Байгаль орчныг хамгаалах, хөрс, ус, агаарын бохирдлыг бууруулах технологийн талаар тусгах; - Сэргээгдэх эрчим хүчийг ашиглах боломжийг тусгах; - Орон сууцны барилгыг гудамж замын сүлжээ, цэцэрлэгжилтийн бүс, суурьшлын бүсүүдтэй уялдуулан хоорондоо аль болохоор зохистой үйлчилгээний хүрээнд байхаар тооцож төлөвлөх; - Дулаан хангамжийн эх үүсвэрийг Орхон аймгийн 2021 оны боловсруулсан гидравлик тооцоололтой уялдуулан төлөвлөж буй орон сууц, хотхоны ачааллыг тооцож /цаашид өргөтгөх/ хангагч байгууллагатай зөвшилцөн холбогдох цэгийг тодорхойлох; - Гал унтраах автомат тоног төхөөрөмж БНбД 21-04-16-ын 5.5-д заасны гал унтраах.
6.	**Баримт бичиг боловсруулах хугацаа**	Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд гэрээ байгуулснаас хойш хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах нь нийт хугацаа 150 хоног байна. /Магадлалаар батлагдах хугацаа ороогүй болно./ Үүнээс: **<u>Эхлэлийн тайлан:</u> /60 хоногт гүйцэтгэнэ/** - Одоогийн байдлын судалгаа, байр зүйн зураглалын тодотгол, инженер геологийн судалгаа дууссан байх; - Холбогдох хангагч байгууллагуудаас төлөвлөлтийн хязгаар дахь суурь мэдээллийг авах; - Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн шийдэл дэвшүүлэх /инженерийн шугам сүлжээ, бүсчлэл, авто замын сүлжээ/; - Олон нийтээр хэлэлцүүлэх /Төлөвлөлтийн хязгаарт хамрагдаж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагаар хэлэлцүүлэн санал авах/; - Барилгажилтын төслийг Аймгийн Ерөнхий архитектор, “ХББЗА” ОНӨААТҮГ-ын Хот дахин хөгжүүлэх, орон сууцны хэсэг, ГХБХБГ, аймгийн ЗДТГ, ОБГ, авто зам болон инженерийн байгууламжийн хангагч

		байгууллагатай тус тус зөвшилцөж гаргасан саналыг шийдэлд тусгах. **<u>Дундын тайлан</u>: /60 хоногт гүйцэтгэнэ/** - Эхлэлийн тайланд өгсөн саналыг тусгаж газар зохион байгуулалт болон архитектур орон зайн төлөвлөлт, дэд бүтцийг тавигдах шаардлагын дагуу төлөвлөлтийг гүйцэтгэсэн байх; - Төлөвлөлтөд холбогдох хангагч байгууллагуудаас санал авч, инженерийн шугам сүлжээ, бүсчлэл, авто замын сүлжээний төлөвлөлт, ой, усны хамгаалалтын бүсчлэлийг тусгаж шийдлийг эцэслэн гаргасан байх; - Олон нийтэд танилцуулах /Төлөвлөлтийн хязгаарт хамрагдаж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад төлөвлөлтийн хувилбарын шийдлийг танилцуулах/; - Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Аймгийн Ерөнхий архитектор, "ХББЗА" ОНӨААТҮГ-ын Хот дахин хөгжүүлэх, орон сууцны хэсэг, ГХБХБГ, аймгийн ЗДТГ, ОБГ, авто зам болон инженерийн байгууламжийн хангагч байгууллагатай тус тус зөвшилцөнө. **<u>Эцсийн тайлан</u>: /30 хоногт гүйцэтгэнэ/** - Төлөвлөлтийн шийдлийг эцэслэн боловсруулсан байх; - Дундын тайланд өгсөн санал, зөвлөмжийг тусган эцсийн байдлаар хүлээлгэн өгөх; **<u>Магадлалын нэгдсэн дүгнэлт:</u>** - Эрх бүхий байгууллагаар Магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулах.
7.	**Баримт бичиг боловсруулахад шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр**	Орон нутгийн хөрөнгө оруулалт
8.	**Захиалагч байгууллага**	Орхон аймгийн ЗДТГ
9.	**Гүйцэтгэгч байгууллага**	Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийн зөвшөөрөлтэй Аж ахуй нэгж, байгууллагыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу сонгон шалгаруулж гүйцэтгүүлнэ.
10.	**Зөвшөөрөлцөх байгууллага**	- "Хот байгуулалтын тухай" хуулийн 17 дугаар зүйл, "Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам"-ын дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтэд танилцуулах, саналыг авах, төлөвлөлтийн шийдлийг аймаг, сум, багт танилцуулах;

		- Аймгийн ЗДТГ, Аймгийн Ерөнхий архитектор, ГХБХБГ, “ХББЗА” ОНӨААТҮГ-ын Хот дахин хөгжүүлэх, орон сууцны хэсэг, аймгийн ЗДТГ, ОБГ болон инженерийн шугам сүлжээний хангагч байгууллагуудтай зөвшилцөх; - Барилгажилтын төслийг “Хот байгуулалтын тухай” хуулийн 8.1.1-д заасны дагуу ИТХ-аар батлуулна. - Барилгажилтынтөслийг улсын магадлалаар батлуулах.

ЗӨВШӨӨРСӨН:

Орхон аймгийн Ерөнхий архитектор бөгөөд “ХББЗА” ОНӨААТҮГ-ын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Хишигжаргал

ХЯНАСАН:

Орхон аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга С.Даваадорж

ГХБХБГ-ын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Г.Буянхүү

БОЛОВСРУУЛСАН:

Орхон аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн барилга, инженерийн шугам сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн Р.Галбаатар

ГХБХБГ-ын Барилга, хот байгуулалтын хэлтсийн инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Нямбаатар

“Хот байгуулалт, барилга захиалагчийн алба” ОНӨААТҮГ-ын Зураг төсвийн хэсгийн дарга Ө.Должинжав